



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

“Жаргалтай инээмсэглэл” арга хэмжээнд  
оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргээс 2024 оныг “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан Олон Улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан 2024 оны 5 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдах “Жаргалтай инээмсэглэл” арга хэмжээнд дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бэлтгэн оролцуулахыг Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв (М.Өсөхдэлгэр)-д үүрэг болгосугай.

2. “Жаргалтай инээмсэглэл” арга хэмжээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 1,050,000 (нэг сая тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тохжилт худалдаа, үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 08 сарын 19-ны өдрийн 1798 дугаар  
захирамжийн хавсралт



“ЖАРГАЛТАЙ ИНЭЭМСЭГЛЭЛ” АРГА ХЭМЖЭЭНД  
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Тоо ширхэг (1 өдөрт)	Хэмжих нэгж	Нийт хоног	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Асар түрээс	5	ш	3	70,000	1,050,000
<b>Нийт дүн</b>						1,050,000